

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

*2024 оны 08 дугаар сарын 27-ны өдөр, Мягмар гараг  
Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-9
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	10-19
<hr/>	
<i>1. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг//</i>	10-18
<i>2. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	18
<i>3. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	19

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны  
08 дугаар сарын 27-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 00 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Л.Гантөмөр, Л.Мөнхбаатар, Н.Номтойбаяр, Э.Одбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пүрэвдорж, Л.Энх-Амгалан.

**Нэг. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Төмөрхүү, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга Д.Цолмон, мөн газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлуvsан, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын зөвлөх П.Мөнхбат нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Б.Нандингэрэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу санал хураалт явуулав.*

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.1.3.Монгол Улсын өмнөд бүс нутгийн зэс, алтны ордуудыг түшиглэн байгуулах зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн байршлыг эцэслэн тогтоож, дэд бүтцийн нарийвчилсан ТЭЗҮ-ийн судалгааг хийж хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 7  
Бүгд: 18  
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 2.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.13 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.1.13.Нууц мөрдөн шалгах ажиллагаанд тавигдах шүүхийн хяналтыг сайжруулж, тус ажиллагаанд өртсөн иргэнд мэдэгдэх, хүний хувийн мэдээллийг хамгаалах, зөрчигдсөн эрхээ шүүхээр хамгаалуулах хуулийн зохицуулалтыг бий болгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 9  
Бүгд: 18  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 2.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.13 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.2.1.13.Нууц мөрдөн шалгах ажиллагаанд тавигдах шүүхийн хяналтыг сайжруулж, тус ажиллагаанд өртсөн иргэнд мэдэгдэх, хүний хувийн мэдээллийг хамгаалах, зөрчигдсэн эрхээ шүүхээр хамгаалуулах хуулийн зохицуулалтыг бий болгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 3.Төслийн 1 дүгээр хавсралтын “2.2.1.Тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол” зорилгод доор дурдсан агуулгатай 2.2.1.21 дэх заалт нэмэх:

“2.2.1.21.Үндэсний цөөнхийн бага, дунд боловсрол эзэмших эрхийг хангах “Хос хэл”-ний бодлого, арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар саналаа татан авч байгаа тухай мэдэгдэж, дээрх саналаар саналт хураалт явуулаагүй болно.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.*

**Ж.Бат-Эрдэнэ:** Дахин санал хураалгах шаардлагатай гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 5

Бүгд: 18

72.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.2.27 дахь заалтыг хасах.

“3.3.2.27.Хутаг-Өндөр сумаас Бага илэнхийн хилийн боомт хүртэл 146 км хатуу хучилттай авто замыг барина.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 5

Бүгд: 18  
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дахин санал хураалгах шаардлагатай гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 5  
Бүгд: 18  
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 2.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.5 дахь заалтын гарчгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.3.5.Төвийн бүс-“Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс”” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 5  
Бүгд: 18  
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дахин санал хураалгах шаардлагатай гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 6  
Бүгд: 19  
68.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 3.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.1.Уул уурхай” зорилтын 3.3.1.11 дэх дараах заалтыг хасах:

“3.3.1.11.“Сайншанд-Баруун-Урт-Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14  
Татгалзсан: 5  
Бүгд: 19  
73.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дахин санал хураалгах шаардлагатай гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14  
Татгалзсан: 5  
Бүгд: 19  
73.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 4.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3.47 дахь дараах заалтыг хасах:

“3.3.3.47.Эрчим хүчний салбарт реформ хийж, салбарын эрх зүйн орчныг сайжруулах ажлын хүрээнд Эрчим хүчний тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулиуд болон холбогдох хууль тогтоомжийг шинэчилнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 6  
Бүгд: 19  
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дахин санал хураалгах шаардлагатай гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14  
Татгалзсан: 5  
Бүгд: 19  
73.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 5.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.4.34 дэх заалтын “хамгаалалтыг” гэснийг “хангалтыг” гэж, “тариалангийн” гэснийг “таримлын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 8  
Бүгд: 19  
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дахин санал хураалгах шаардлагатай гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 7  
Бүгд: 20  
65.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 15  
Татгалзсан: 5  
Бүгд: 20  
75.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 6.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.4.8 дахь дараах заалтыг хасах:

“3.3.4.8.Бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах үүднээс малчдын өвөлжөө, хаваржааны доорх газрын хоорондын доод зай хэмжээг, мөн гүний хурдгийн цооног хоорондын доод зай хэмжээг тогтоох, дээрх газруудыг эзэмших, ашиглах эрхийг бусдад шилжүүлэхийг хориглох, арилжихыг хориглох, зөвхөн үр хүүхэддээ өвлүүлдэг байх эрх зүйн өөрчлөлт оруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 15  
Татгалзсан: 5  
Бүгд: 20  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дахин санал хураалгах шаардлагатай гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 16  
Татгалзсан: 4  
Бүгд: 20  
80.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 7.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 17 дахь мөрний “Үр дүн” баганын “Олон улсын ур чадварын үзүүлэлт” гэснийг “Ур чадварын индексийг 8 байраар ахиулна.” гэж өөрчилж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Олон улсын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр” гэж, “Хэмжих нэгж” баганад “түвшин” гэж, “Суурь он” баганад “2023” гэж, “Суурь түвшин” баганад “64/64” гэж, Зорилтот түвшний “2025 он” баганад “62” гэж, “2026 он” баганад “60” гэж, “2027 он” баганад “58” гэж, “2028 он” баганад “56” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв, Дэлхийн өрсөлдөх чадварын төв” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Олон эх үүсвэр” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жилд нэг удаа” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 16  
Татгалзсан: 4  
Бүгд: 20  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дахин санал хураалгах шаардлагатай гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 16  
Татгалзсан: 4  
Бүгд: 20  
80.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** 8.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 15 дахь мөрийг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 16  
Татгалзсан: 4  
Бүгд: 20  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаагийн тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан хариулж, тайлбар хийв.

*Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5-д анхдагч болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан Байнгын хороо төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ хууль тогтоомжийн хоорондын уялдааг хангах зорилгоор холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан хамтад нь хэлэлцүүлж болно гэсний дагуу “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх тухай мэдэгдэв.*

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

**Ж.Бат-Эрдэнэ:** “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 16  
Татгалзсан: 4  
Бүгд: 20  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Горимын саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Ж.Бат-Эрдэнэ:** Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 17  
Татгалзсан: 3  
Бүгд: 20  
85.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 13 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.** “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл



Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Б.Нандингэрэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Ж.Бат-Эрдэнэ:** “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 15  
Татгалзсан: 5  
Бүгд: 20  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, О.Номинчимэг нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргав.

Нийт 20 гишүүнээс 17 гишүүн дэмжиж, 85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

*Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.*

*Уг асуудлыг 13 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.** “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Б.Нандингэрэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Ж.Бат-Эрдэнэ:** “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17  
Татгалзсан: 3  
Бүгд: 20  
85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

*Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.*

*Уг асуудлыг 13 цаг 46 минутад минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 46 минут үргэлжилж, 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 46 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 27-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим  
13 цаг 00 минут.

### ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ж.Бат-Эрдэнэ:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хороонд оролцож байгаа гишүүдийг та бүхэнд танилцуулъя.

Ж.Бат-Эрдэнэ гишүүн ирсэн, Д.Амарбаясгалан гишүүн ирсэн, Б.Батбаатар гишүүн ирсэн, Ө.Шижир гишүүн ирсэн, Б.Баярбаатар гишүүн ирсэн, Ж.Баярмаа гишүүн ирсэн, Э.Болормаа гишүүн ирсэн, С.Бямбацогт гишүүн ирсэн, Л.Гантөмөр гишүүн хаана? Алга байна. Т.Доржханд гишүүн ирсэн, С.Зулпхар гишүүн ирсэн, Б.Найдалаа гишүүн ирсэн, О.Номинчимэг гишүүн ирсэн, Ц.Сандаг-Очир гишүүн ирсэн, Ц.Туваан гишүүн ирсэн, О.Алтангэрэл гишүүн ирсэн, Н.Учрал гишүүн ирсэн, О.Цогтгэрэл гишүүн ирсэн. Ингээд ирц бүрдсэн тул.

Тайлбар, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д хуралдааны ирцийг гишүүний сонгогдсон тойрог, нэрээр нь хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд хүрэлцэн ирээгүй гишүүн, хуралдаан тасалсан гишүүн, дарааллыг танилцуулна гэсэн. Ямар ч байсан би ирсэн гишүүдийг бол танилцууллаа. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж ирц бүрдсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны

2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Гишүүд сая чуулганы хуралдаан түр завсарлаад Байнгын хороодын хуралдааныг зарласан байгаа. Гишүүд хуралдаандаа хүрэлцэн ирэхийг, саяын дурдсан гишүүд хуралдаандаа хүрэлцэн ирэхийг хүсэж байна.

Хэлэлцэх асуудлаа танилцуулъя. Гурван асуудал байгаа.

Нэгдүгээр асуудал, “Монгол Улсын Засгийн газрын 2024-28 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, эцсийн хэлэлцүүлэг.

Хоёр. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Гурав. “Тогтоолын хавсралт өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл гэсэн гурван асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Саналтай гишүүд байна уу?

Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. Нэгдсэн хуралдааны хэлэлцүүлгээр олгохын дэмжлэг авсан.

**“Монгол Улсын Засгийн газрын 2024-28 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.**

Эцсийн хэлэлцүүлгийн танилцуулгыг та бүхэнд уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд ишлэжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулах хуулийн төслийн холбогдох зүйл, заалт, хэсэг заалттай уялдуулахаар Байнгын хороонд ишлэжүүлсэн 3 санал, нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хувааж эмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасныг баримтлан 8 саналаар тус тус санал хураалт явуула.

Байнгын хорооны хороо тогтоолын төслийн 3 дахь заалтыг хасах зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан Байнгын хороо төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ хууль тогтоомжийн хоорондын уялдааг хангах зорилгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийг баримтлан “Монгол

Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай”, “Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг тогтоолын төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Танилцуулгатай холбоотойгоор асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна. Санал хураалтыг явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-д заасны дагуу, 42.2.3, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д зааснаар хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу хураалгах саналууд. Ингээд 3 санал байгаа. Чуулганы хуралдаанаас, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах санал авсан 3 санал байгаа. Үүний

1.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.1.3.Монгол Улсын зэсийн ордуудыг түшиглэн зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн байршлыг эцэслэн тогтоож, дэд бүтцийн нарийвчилсан ТЭЗҮ-ийн судалгааг хийж хэрэгжүүлнэ.”

Энэ Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам саналаа ирүүлсэн. Ер нь бол Ганбаатар гишүүний гаргасан санал байгаа. Санал хураалт.

Саяын би сая хэлсэнгүй төстээ эхлээд, төстийн санал явуулчихъя гэсэн тэрийгээ хэлэлгүй санал хураалт явуулчихлаа. Тийм болохоор санал хураалтыг хүчингүй болгоод туршилтын санал эхлээд явуулаадахъя. Санал хураалт.

Түрүүний санал хураалт хүчингүйд тооцож, 66.7 хувиар санал дэмжигдлээ. Хүчингүй санал, хураалтыг хүчингүй болгоод.

Одоо шууд санал хураалт явуулчихъя. Санал хураалт.

61.1 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр хавсралтын 4.2.1.13 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах, 4.2.1.13 заалт шүү.

“4.2.1.13.Нууц мөрдөн шалгах ажиллагаанд тавигдах шүүхийн хяналтыг сайжруулж, тус ажиллагаанд өртсөн иргэнд мэдэгдэх, хүний хувийн мэдээллийг хамгаалах, зөрчигдсөн эрхээ шүүхээр хамгаалуулах хуулийн зохицуулалтыг бий болгоно.”. Санал хураалт.

Горимын санал Болормаа гишүүн. Болормаа гишүүний микрофоныг нээе.

**Э.Болормаа:** Даргаа би энэ зөвшөөрөх гэж байсан чинь энэ техникийн алдаанаас болоод татгалзсанд орсон байна. Тэгэхээр санал хураалтыг дахиж явуулж өгнө үү гэж горимын санал гаргая.

**Ж.Бат-Эрдэнэ:** Болормаа гишүүний гаргасан саналын дагуу санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдсэн тул саяын хураасан санал хүчингүй боллоо. Ингээд 2 дугаар асуудлаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын “2.2.1.Тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол” зорилтод доор дурдсан агуулгатай 2.2.1.21 дэх заалт нэмэх:

“2.2.1.21.Үндэсний цөөнхийн бага, дунд боловсрол эзэмших эрхийг хангах “Хос хэл”-ний бодлого, арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлнэ.”.

Зуллхар гишүүн үг хэлнэ.

**С.Зуллхар:** Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Боловсролын сайдтай уулзсан тэгээд энэ асуудал угаасаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа Бага, дунд боловсролын хууль, бусад хөтөлбөрөөр бол хэрэгжээд явж байгаа. Хэрэгжих бүрэн боломжтой гэж үзсэн учраас энийг татъя гэсэн ийм санал гаргаж байгаа юм.

Гэхдээ чуулганы хуралдаан дээр ийм асуудал болсон юм байгаа юм. Энэ Үндсэн хуультай зөрчилдсөн байж болзошгүй гэдэг ийм асуудал яригдсан. Тэгээд гүйцээн боловсруул гэсэн юм. Тэгээд бид яах вэ манай Байнгын хорооноос ч гэсэн бид энэ асуудлыг судалсан. Би ч гэсэн анх саналаа гаргахдаа Үндсэн хуулиа барьж л гаргасан санал л даа. Тэгэхээр энэ бол

Үндсэн хууль зөрчөөгүй гэдгийг бас хуралдааны тэмдэглэлд бас тэмдэглүүлмээр байгаа юм хуралдаанд. Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн 2-т бол, 8 дугаар зүйлийн 1-д Монгол хэл бол төрийн албан ёсны хэл байна гэхсэн байгаа.

2-т нь энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь хүн амын өөр хэл бүхий үндэсний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө гээд ингээд заачихсан юм. Тэгэхлээр Үндсэн хууль эрс зөрчөөгүй, холбогдох Монгол хэлний тухай хууль дээр ч гэсэн, Боловсролын ерөнхий хуулиар ч гэсэн энэ зохицуулагдсан байгаа юм. Тэгэхээр энийг бас ингээд тэмдэглүүлэхгүй бол болохгүй байх.

Уг нь энэ санааны зорилго бол ийм юм байгаа юм л даа. Баян-Өлгий аймгийн жишээ нь сурагчид энэ 20 гаран жил бол ЭИШ-ын шалгалтад 21-д л явж байгаа юм. Тэгээд энэ бол төрийн албан ёсны хэлээ сайн эзэмшээгүйгээс болоод энэ арга зүй нь бүрэн хэрэгжихгүй байгаагаас болоод л гарч байгаа зүйл. Тэгээд энийг ер нь цаашидаа залруулъя гэдэг чиглэл авсан. Тэгээд эндээс ингээд тайлан гарчихсан байгаа юм өнгөрсөн жилийн. Энэ чиглэлээр ажил хийгдээд явж байгаа учраас энийг, би энэ саналыг татъя гэж тийм саналаа оруулж байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Зулхар гишүүний гаргасан саналын дагуу санал татагдаж байна. Гэхдээ хэлсэн үг нь ингээд протоколд тэмдэглээд үлдэнэ. Дараагийн санал.

2 дугаар санал. Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42.2.3-д заасны дагуу санал хураалтыг явуулъя.

42.2.3.нэгдсэн хуралдаан, энэ Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42.2.3-ыг би та бүхэнд танилцуулъя.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн гэсэн ийм тохиолдол байгаа шүү.

Тийм болохоор энэ сая Байнгын хороон дээр унасан санал ороод чуулган дээр дэмжигдсэн шүү дээ. Цогтгэрэл гишүүн саналаа өгчхөөд гарчих. Одоо ерөөсөө хэдхэн санал байж байгаа. Тийм, тийм болохоор энэ дахиад гуравны хоёроор дэмжигдэх ёстой ийм санал орж ирж байгаа юм.

1.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.2.27 дахь заалтыг хасах.

“3.3.2.27.Хутаг-Өндөр сумаас Бага илэнхийн хилийн боомт хүртэл 146 км хатуу хучилттай авто замыг барина.”. Энэ төслийн 1.3.3.4-д тусгагдсан ийм давхардсан заалт байгаа шүү. Тийм Бага илэнхээс Хутуг-Өндөр-өөс гэж байсан тэнд заалт дээр бол Бага илэнхээс 1.3.3.4-д бол Бага илэнхээс Хутуг-Өндөр хүртэлх гээд ингээд заалт давхардаж байгаа тул хасъя гэсэн ийм саналтай байж байгаа. Санал хураалт.

Ингээд 18 гишүүнээс 13 гишүүн дэмжээд 72.2 хувиар дэмжигдсэн тул санал хураалтыг явуулъя. Дахиад санал хураалт. Одоо саяын төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.2.27 дахь заалтыг хасах гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт.

18 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 72.2 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.3.5 дахь заалтын гарчгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.3.5.Төвийн бүс-“Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс””. Санал хураалт.

72 хувиар санал дэмжигдлээ. Санал хураалт.

72.2 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.3.1.Уул уурхай” зорилтын 3.3.1.11 дэх дараах заалтыг хасах:

“3.3.1.11.“Сайншианд-Баруун-Урт-Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлнэ.”. Санал хураалт.

19 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 68.4 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалт.

19 гишүүнээс 14 гишүүн дэмжиж, 73.7 хувиар санал дэмжигдлээ.

Аль дээр? Дэг асуух гээд байна. Харин наадхаа сайн хараадах даа. Наадах чинь яг ингээж байна уу, үгүй юу? Энэ чинь юу билээ?

4.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.3.47 дахь дараах заалтыг хасах:

“3.3.3.47.Эрчим хүчний салбарт реформ хийж, салбарын эрх зүйн орчныг сайжруулах ажлын хүрээнд Эрчим хүчний тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулиуд болон холбогдох хууль тогтоомжийг шинэчилнэ.”. Санал хураалт.

73.7 хувиар санал дэмжигдлээ.

Одоо санал хураалт.

68.4 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.4.34 дэх заалтын “хамгаалалтыг” гэснийг “хяналтыг” гэж “тариалангийн” гэснийг таримлын гэж өөрчлөх. Санал хураалт.

73.7 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалт. Тийм 2 дахь санал нь.

57.9 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр хавсралтын 3.3.4.8 дахь дараах заалтыг хасах.

3.3.4.8.Бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах үүднээс малчны өвөлжөө хаваржааны доорх газрын хоорондын доод зай хэмжээг мөн гүний худгийн цооног хоорондын доод зай хэмжээг тогтоох, дээрх газруудыг эзэмших, ашиглах эрхийг бусдад шилжүүлэхийг хориглох, арилжихыг хориглох зөвхөн үр хүүхдэдээ өвлүүлэх, өвлүүлдэг эрх зүйн орчныг эрх зүйн өөрчлөлт оруулна. Санал хураалт.

Учрал гишүүн. Учрал гишүүний микрофоныг нээе.

**Н.Учрал:** Энэ төхөөрөмж гацсан байна. Тэгээд дахин санал хураахыг хүсье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал гишүүний гаргасан саналын дагуу, горимын саналын дагуу саяын өгсөн саналыг хүчингүй болгоё гэсэн санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

75 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалт.

75 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалт, 2 дахь санал хураалт.

20 гишүүнээс 14 гишүүн санал өгч, 70 хувиар санал дэмжигдлээ. Яагаад унтарчхаад байна?

Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 17 дахь мөрний “Үр дүн” баганын “Олон улсын ур чадварын үзүүлэлт” гэснийг “Ур чадварын индексийг 8 байраар ахиулна.” гэж өөрчилж, “Шалгуур үзүүлэлт” баганад

“Олон улсын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр” гэж, “Хэмжих нэгж” баганад “түвшин” гэж, “Суурь он” баганад “2023” гэж, “Суурь түвшин” баганад “64/64” гэж, Зорилтот түвшиний “2025 он” баганад “62” гэж, “2026 он” баганад “60” гэж, “2027 он” баганад “58” гэж, “2028 он” баганад “56” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв, Дэлхийн өрсөлдөх чадварын төв” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Олон эх үүсвэр” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жилд нэг удаа” гэж нэмэх. Санал хураалт.

80 хувиар санал дэмжигдлээ.

Одоо 2 дахь санал хураалт. Санал хураалт.

20 гишүүнээс 16 гишүүн дэмжиж, 80 хувиар санал дэмжигдлээ.

8.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын 15 дахь мөрийг бүхэлд нь хасах. Санал хураалт.

20 гишүүнээс 16 гишүүн дэмжиж, 80 хувиар санал дэмжигдсэн тул 2 дахь санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

80 хувиар 20 гишүүнээс 16 гишүүн дэмжиж, 80 хувиар.

Байна уу? Номинчимэг гишүүний микрофоныг нээе.

**О.Номинчимэг:** Баярлалаа. Бүгдээрэнд нь өдрийн мэнд хүргэе.

Чуулганы үеэр энэ хууль судлалын институц байгуулна гэсэн асуудал хасах санал маань унаад тэгээд горим гаргасан боловч дэмжигдээгүй. Тэгээд энэ дээр Тэмүүжин гишүүн дараах санал хураалтынх нь дараа энэ ингээд болохгүй Засаг руу та нар эрхээ шилжүүлэх гэж байна шүү гэдэг дээр үг хэлээд, Амарбаясгалан дарга чиглэл өгсөн байхгүй юу. Үгүй үгүй санал хураалт

яваагүй байхгүй юу. Тэгэхээр чинь шууд яваагүй яваагүй яваагүй.

Тэгэхээр энэ би дэгээрээ би ингээд одоо төсөл дээрээ хасчихсанаар орчихсон. Гэхдээ энэ дээр чиглэл өгөөд шууд санал хураагаад Байнгын хороон дээрээ бид нар хасах юм байх гэсэн чинь ингэчихсэн байхаар энэ маань яг процесс нь зөв үү л гэдгээ би чекэлж байгаа. Хасах саналтай. Байнгын хороо угаасаа хасъя гэсэн.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тэгэхээр хас гэж байгаа юм уу?

**О.Номинчимэг:** Хас гэж байгаа. Гэхдээ хасаж байгаа процесс нь чуулганы дэгээ зөрчсөн үү, үгүй юү гэдэг дээр шалгах ёстой байх. Би бол ойлгохдоо чиглэл өгөөд гүйцээн боловсруулах чиглэл өгсөн гэж ойлгоод байхгүй юу. Тэгэхээр санал хураалт явалгүйгээр наад чинь.

**Ж.Бат-Эрдэнэ:** Болормаа гишүүний микрофоныг нээе. Болормаа гишүүн.

**Э.Болормаа:** Туваан сайд гарахаас өмнө асуулт асуух гэсэн юм. Байнгын хорооны гишүүд ээ би нэлээн, Хэрэг эрхлэхийн сайд аа, Учрал сайд аа,

**Ж.Бат-Эрдэнэ:** Учрал сайд аа,

**Э.Болормаа:** Би Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй холбоотой нэг асуулт асуух гэсэн юм. Туваан сайд байгаа дээр.

Бид нар Төрийн байгуулалтын байнгын хорооныхоо санал, дүгнэлтээ 8 сарын 15-ны өдөр гаргасан. Тэгээд 8 сарын 16-ны өдөр Ховд аймгийн Мянгад суманд байрлах Халзан Бүргэдэй төслийн үйл ажиллагааг сэргээх тухай гэдэг бичгийг Уул уурхайн яамнаас явсан байна.

Тэгэхээр би Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Уул уурхайн яамнаас юу гэж асуух гээд байна гэхээр энэ үйл



ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэж дуусаагүй, батлаагүй байхад та нар ямар түргэн шуурхай ажилдаа орж байгаа юм бэ? Энэ газрын ховрын элемент гэдэг бол маш ноцтой асуудал. Одоо Үйл ажиллагааны хөтөлбөр дээр орсноор газрын ховрын элемент боловсруулах үйлдвэрийн төслүүдийг бодлогоор дэмжинэ гээд 3.3.1.8 гэж орсон байгаа. Бодлогоор дэмжинэ гэж яг юу гэсэн үг болоод ийм хурдтай ажилдаа орж байгаа юм бэ? Энэ бол зүгээр нүүрс, зэс, алт биш. Газрын ховор элемент гэдэг бол дагаж цацрагт идэвхт бодис ялгардаг Монгол Улсын хэмжээнд стратегийн бүтээгдэхүүн болох ёстой ийм асуудал.

Стратегийн бүтээгдэхүүн болгох ёстой асуудал дээр бид нар Их Хурлаар бодлогоо тодорхойлох ёстой. Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого гэж стратегийн асуудал дээр баримталдагтай адилхан газрын ховор элементийг Монгол Улс хэрхэн цаашидаа хөгжүүлэхээ Их Хурлаар оруулж ирээсэй гэж хүсэж байна.

Тэгэхээр иймэрхүү байдлаар Үйл ажиллагааны хөтөлбөр батлагдаагүй байхад ийм хурдтай ажиллаж байгаа нөхцөлд би зарчмын зөрүүтэй санал гаргаж энэ үйл ажиллагааны хөтөлбөртөө бодлогоор дэмжинэ гэдгээ бодлогоо тодорхойлж, эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэдгээр юуны өмнө оруулж ирээч гэж хүсэж байна. Энэ бол Ховд аймгийн Мянгад сумын бөгөөд Ховд аймгийн иргэдэд маш ноцтой асуудал. Өнгөрсөн жил Монгол Улсын Ерөнхий сайд газар дээр нь очоод иргэдтэй уулзсаны үндсэн дээр Засгийн газрын хурлаар энэ төслийг зогсоох шийдвэр гаргасан.

Гэтэл ямар хурдтай сэргэж байна вэ? Энэ ашигт малтмал гэдэг бол нэл ашиг сонирхолд нэрвэгдсэн салбар байгаа. Бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Энийг сэргээх шийдвэрийг гаргахдаа Ховд аймагт очиж ажилласан юм уу, иргэдтэй очиж уулзсан юм уу? Яг нөхцөл

байдал юу өөрчлөгдсөн гэж сэргээхээр шийдвэр гаргаж байгаа юм бэ? Засгийн газар Үйл ажиллагааны хөтөлбөрөө батлаагүй байж байж ямар үндэслэлтэйгээр ийм юм хийж байгаа юм бэ гэдэг дээр би асуулт асуумаар байна. Салбарын сайдаас нь, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаас. Энэ төсөл яг ямар үр ашигтай юм бэ? Ямар судалгаа хийсэн юм бэ?

**Ж.Бат-Эрдэнэ:** Асуултаа асуучихлаа. Туваан сайд хариулъя.

**Ц.Туваан:** Энэ асуудлыг удаа дараагийн бичиг манай яаман дээр ирсэн. Энэ ганц энэ удаагийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт ч биш, өмнөх Засгийн газрууд дээр эрх зүйн бичиг баримтууд дээр уул уурхайн салбарыг дэмжих бодлого, тэр дундаа газрын ховор элементтэй холбоотой асуудлыг дэмжих бодлогууд орж ирж байсан. Үүнтэй ч адилхан энэ удаагийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт энэ бодлого орж ирээд ингээд хэлэлцэгдээд явж байгаа гэдгийг хэлье.

Энэ дээр ямар нэгэн ашиг сонирхол янз бүрийн асуудал байхгүй. Ашиг сонирхолтой асуудал байвал хуулийн өмнө энэ асуудлыг шалгуулахад бэлэн байгаагаа хэлье. Энэ удаагийн Засгийн газар дээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болгож өөрчилж оруулж ирсэн. Энэ бодлого бол Монгол Улсад энэ аж үйлдвэрийн салбар, эрдэс баялгийн салбарыг хөгжүүлж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын бүрдэл, мөн улс орны эдийн засагт нэн шаардлагатай төслүүдийг хэрэгжүүлэх ийм зорилт тавьсан.

Монгол Улс бол одоо бүгд мэдэж байгаа дотоодын нийт бүтээгдэхүүн, улсын төсвийн бүрдэлт, экспортын орлого гээд маш их орлогуудаа уул уурхайн салбараас олдог нь нууц биш болсон. Тэгээд өнөөдрийн байдлаар Монгол Улсад хэрэгжүүлэх нэн шаардлагатай энэ Засгийн газрын үйл

ажиллагаанд дотор тусгагдсан 14 мега төслийг хүртэл хэрэгжүүлэхэд маш их хөрөнгийн санхүүгийн асуудал шаардлагатай.

Тийм уचाас Монгол Улсын Засгийн газрын бодлогод уул уурхайн салбараа илүү хурдтай, түлхүү хөгжүүлэх энэ бодлого орж ирж байгаа гэдгийг хэлье.

Ямар нэгэн байдлаар Халзан бүргэдэйн асуудал дээр улсын салбарын хяналтын байцаагчийн дүгнэлт гарсан зөрчил нь арилгагдаад, энэ зөрчил арилсан тул байцаагч энэ эрхийг сэргээх шийдвэр гарсан гэж ийм ойлголттой байгаа. Тэгээд Болормаа гишүүнд бас энэ талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг бас бичиг баримттай нь өгье гэж хариулья.

**Ж.Бат-Эрдэнэ:** Болормаа гишүүн, үгүй үгүй Болормаа гишүүн танд бас асуулт өгчихлөө. Тэгээд яг хэлэлцэж байгаа асуудалтай холбоогүйгээр. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоогүйгээр асуулт асууж тэгээд хариулт авчихлаа. Одоо орохгүй шүү дээ.

Одоо бол зарчмын зөрүүтэй санал дээр бид нар санал хурааж байгаа шүү дээ. Тийм болохоор наадах чинь дахиж орох бололцоогүй. Тийм болохоор та Засгийн газрын хүрээнд Мөрийн хөтөлбөр батлагдах хүрээнд нь л ярихаас өөр арга байхгүй. Одоо өнгөрсөн.

Дараагийн санал хураалт.

Тогтоолын төслийн 3 дахь заалтыг хасах гэсэн заалт зарчмын зөрүүтэй санал гарч ирсэн. Үүнтэй уялдуулаад чуулганы нэгдсэн хуралдаан дээр энэ санал дэмжигдээд явчихсан тул дэгийн тухай хуулийн 42.5-д анхдагч болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан Байнгын хороо төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ хууль тогтоомжийн хоорондын уялдааг хангах зорилгоор холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хуулийн

төслийг боловсруулах хамтад нь хэлэлцүүлж болно гэсэн байгаа. Тэгээд үүний хүрээнд бол та бүхэнд тараасан байж байгаа “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг оруулж ирж байгаа юм.

Тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын хурлаас тогтоох нь:

1. Монгол Улсын Их Хурлын Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай 2024 оны 64 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.1 Хангайн бүс хэсгийн бүсийн хөгжлийн зорилтын Орхоны хөндий, Хангайн нурууны байгалийн онцлогт тулгуурлан аялал жуулчлал, боловсруулах үйлдвэрлэлийг дагнан хөгжүүлсэн дэлхийн нүүдэлчдийн соёлын голомт нутаг, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүс болно гэснийг дэлхийн нүүдэлчдийн соёлын голомт нутаг, соёлын бүтээлч үйлдвэрлэлд тулгуурласан уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн хот байгуулалтын дэд бүс болно гэж, 3.2 Баруун бүс хэсгийн бүсчилсэн хөгжлийн зорилтын соёлын өвд түшиглэсэн тусгай сонирхлын аялал жуулчлалаар төрөлжиж, мал аж ахуй, газар тариалангийн нөөцөд тулгуурлан эко үйлдвэрлэлийн хоршилт бүхий тогтвортой хөгжлийн бүс болно гэснийг соёлын өв, эрчим хүчний нөөцөд түшиглэн эрчим хүчний төрөлжсөн байгалийн аялал жуулчлалын дэд бүс болно гэж, 3.3 Хойд бүс хэсгийн бүсийн хөгжлийн зорилтын аялал жуулчлалын амралт сувилал, хүнд үйлдвэрээр төрөлжсөн аялал жуулчлал, аж үйлдвэрлэлийн хөгжлийн бүс болно гэснийг байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн аж үйлдвэрийн дэд бүс болно гэж, 3.4 Төвийн бүс хэсгийн төвийн бүс, хөгжлийн зорилтын холбогдох уламжлалт мал аж ахуй болон

эрчимжсэн мал аж ахуй боловсруулах үйлдвэрээр төрөлжиж дотоодын хэрэгцээгээ бүрэн хангасан эрүүл хүнс үйлдвэрлэгч экспортлогч бүс болно гэснийг холбогдон хөдөө аж ахуй болон байгалийн нөөцөд тулгуурлан хөдөө аж ахуйн төрөлжсөн аж үйлдвэрийн бүс болно гэж, 3.5 Зүүн бүс хэсгийн бүсийн хөгжлийн зорилтын түшиглэсэн аялал жуулчлал, уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн боловсруулах үйлдвэрлэлээр төрөлжсөн олон улсын худалдаа, тээвэр ложистикийн таталцлын бүс болно гэснийг түшиглэн түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн, эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүс болно гэж, 3.6 говийн бүс хөгжлийн бүсийн хөгжлийн зорилгын өндөр технологи бүхий уул уурхайн хүнд үйлдвэрлэлээр дагнан төрөлжсөн говийн унаган байгаль, түүх, соёлын өв, палеонтологийн нөөцөд түшиглэсэн аялал жуулчлал хөгжсөн үндэсний баялгийн санг бүрдүүлэгч бүс болно гэснийг уул уурхайн говийн унаган байгаль, түүх, соёлын өв, палеонтологийн нөөцөд түшиглэн аж үйлдвэрийн төрөлжсөн ногоон эрчим хүчний дэд бүс болно гэж тус тус өөрчилсүгэй.

2.Тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөгдсүгэй гэж.

Санал хураалт.

20 гишүүнээс 16 гишүүн дэмжиж, 80 хувиар санал дэмжигдлээ.

Горимын санал гаргаж байна. Энэхүү тогтоолыг эцэслэн батлах үе шаттай хамт анхны хэлэлцүүлгээр баталъя гэсэн горимын саналыг дэвшүүлж байна. Горимын саналтай холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна. Санал хураалт.

20 гишүүнээс 17 гишүүн дэмжиж, 85 хувиар санал дэмжигдлээ.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-28 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Танилцуулгыг миний бие танилцуулчихъя.

13.43 цаг

**Хоёр. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.**

Тогтоолын төсөл та бүхэнд тараагдсан байж байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна.

Үг хэлэх гишүүд байна уу?

Алга байна.

Санал хураалт явуулъя.

20 гишүүнээс 15 гишүүн дэмжиж, 75 хувиар санал дэмжигдлээ.

Миний бие дэмжсэнээр болон Номинчимэг гишүүнийг дэмжсэнээр протоколд тусгаж байна.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ? Баярбаатар гишүүн танилцуулъя. Сүүлийнх нь тийм.

“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалд оръё.

13.45 цаг

**“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.**

*Та бүхэнд танилцуулсан байгаа.*

*Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?*

*Алга байна.*

*Үг хэлэх гишүүд байна уу?*

*Алга байна.*

*Тогтоолын төслийг танилцуулъя.*

*Тогтоолын төсөл, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт.*

*20 гишүүнээс 17 гишүүн дэмжиж, 85 хувиар санал дэмжигдлээ.*

*Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдааны Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг гишүүн танилцуулъя.*

*Ингээд Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье.*

*13.46 цаг*

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР**